

ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

Дугаар № 128 / 2022

20²² оны 11 р сарын 29

Улаанбаатар хот

Энэхүү түрээсийн гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө /цаашид түрээслэгч гэх/ нөгөө талаас түрээслүүлэгч иргэн А.Батболд рд-78022571 /цаашид түрээслэгч гэх /хамтад нь/ цаашид талууд гэх/ нар нь Монгол Улсын Иргэний хуулийн 318-326 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1. Гэрээний зорилго нь “Зуухны нарийн үнсийг зориулалтын автомашинаар тээвэрлэх” ажлыг дор дурдсан хугацаанд гүйцэтгэх, Түрээслэгч нь гүйцэтгэсэн ажлыг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тогтоох, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний нөхцөл, ерөнхий зүйл, хугацаа

2.1. Түрээслүүлэгч нь “Зуухны нарийн үнс зориулалтын автомашинаар тээвэрлэх” (цаашид “ажил” гэх) -ыг 29-08 УНХ улсын дугаартай Dong Fong DFL 1250 маркийн өөрийн эзэмшлийн автомашинаар эзэмшигч А.Батболд нь 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн 2022 оны 11 дүгээр сарын 30-нд дуусгах ба 2/хоёр/хоногт багтаан гүйцэтгэнэ. Компанийн горим ажиллагаатай холбоотойгоор эхлэх өдрийг мөрдөх боломжгүй болсон бол наряд нээгдсэн өдрөөр тооцож болно

Гурав. Түрээсийн төлбөр

3.1. Зуухны нарийн үнсийг зориулалтын автомашинаар тээвэрлэх ажлын үнэ нь нэг тонн үнсийг 20,000 /хорин мянга /-н төгрөгөөр тээвэрлэнэ. Автомашины өөрийн жин-15760, Нарийн үнс ачсан жин- 41,040 төгрөг, нарийн үнсний жин-25,280кг, нэг рейсийн үнэ 25,280кг* 20,000төг = 505,600 /таван зуун таван мянга зургаан зуу/-н төгрөг. Гэрээний нийт үнэ -9/рейс/*505,600 төгрөг= 4,550,400 /дөрвөн сая таван зуун тавин мянга дөрвөн зуу/-н төгрөг. Шатахууны үнэ ороогүй дүн болно. Энэ нь НӨАТ, даатгалтай холбоотой бүх зардлууд багтсан болно.

3.2. Гэрээт ажлын төлбөрийг гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш нэхэмжлэлийн дагуу 30 хоногийн дотор багтаан гүйцэтгэгчийн Хаан банкны 5075406032 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

- 4.1. Гэрээт ажлыг заагдсан маршрут, хуваарийн дагуу, гэрээний үнэд багтаан гэрээний хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.
- 4.2. Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ замын хөдөлгөөний дүрэм, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаж, галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд түрээслэгчийн шаардлагаар ажлыг зогсооно.
- 4.3. Ажил гүйцэтгэх хугацаанд Эрчим хүчний системд мөрдөгдөж буй ТАД, ААД болон холбогдох бусад дүрэм журмыг мөрдөж ажиллана. Түрээслэгчийн тавьсан хууль ёсны шаардлага зөвлөмжийг заавал биелүүлнэ.
- 4.4. Ажил гүйцэтгэхдээ автомашин, техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг станцын хашаанд оруулах үедээ харуул хамгаалалтын ажилтанд бүртгүүлэн эрх бүхий албан тушаалтнуудын зөвшөөрөл, хяналтаар нэвтрүүлнэ.
- 4.5. Түрээслүүлэгч тал түрээслэгчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 4.6. Ажил гүйцэтгэгч нь уг ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрдөнө
- 4.7. Ажил үйлчилгээг нэгэнт эхэлснээс хойш гэрээг цуцлах санал тавихгүй.
- 4.8. Түрээслүүлэгч нь станцын хашаанд нэвтрэх үнэмлэх авч, захиалагчийн дотоод дүрэм, журам, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөн ажиллана. Түрээслэгч талын зөвшөөрлөөр шаардлагатай үед илүү цагаар ажиллаж болно.
- 4.9. Түрээслүүлэгч нь зуухны нарийн үнсийг ДЦС-4 ТӨХК-ийн хашаанд буулгана. Түрээслүүлэгч нь батлагдсан маршрут, хуваарийн дагуу явна. Автомашины стометрын заалт, тээвэрлэсэн ачааны жин тонныг /пүүлүүлж/, зам явах хуудсыг цаг тухайд нь хөтөлж явна. Автомашины түлшний зардлаа түрээслүүлэгч тал бүрэн хариуцна. Автомашины бүрэн бүтэн байдал эвдрэл гэмтлийг гүйцэтгэгч тал хариуцна.

Тав. Түрээслэгчийн эрх, үүрэг

- 5.1. ХАБ, ААД-ийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан эсэргүүцсэн, дүрэм журам, стандартыг зөрчсөн, зам тээврийн хэрэгт холбогдсон нь холбогдох байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.
- 5.2. Гүйцэтгэсэн ажлыг гэрээ дуусмагц комисс дүгнэнэ.
- 5.3. Ажил гүйцэтгэх явцад түрээслүүлэгчийн ажилд түрээслэгч талаас хяналтыг тогтмол тавьж ажиллана.
- 5.4. Түрээслэгч талаас гэрээний үнийн дүнг өөрчлөхгүйгээр зарим нэгэн ажил, ажлын тоо хэмжээнд түрээслүүлэгчтэй тохиролцсоны үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

Зургаа. Талуудын хүлээх үүрэг хариуцлага

- 6.1. Түрээслүүлэгчийн буруугаас тээврийн ажлын хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 %-иар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги гэрээний үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.2. Түрээслэгчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1% -ийн алданги хүлээх ба гэрээний үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.3. Компанийн дотоод дүрэм, журам зөрчих, ажлын байранд ёс бус үйл ажиллагаа явуулах согтууруулах ундаа авчирсан, уусан тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээг цуцлах ба гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхөөс татгалзана.
- 6.4. Алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 6.5. Түрээслэгчийн саналаар нэмэлт ажил хийгдэх шаардлага гарсан болон зардал дутуу тусгагдсан, үнийн ямар нэгэн зөрүү гарсан тухай бүр 2 /хоёр/ тал харилцан тохиролцож акт протоколоор баталгаажуулж шийдвэрлэнэ.
- 6.6. Түрээслэгчийг төлөөлж гэрээний үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн АХММХМ инженер Н.Сайнбилэг хариуцан ажиллана. Утас-98109919
- 6.7. Түрээслүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг иргэн А.Батболд хариуцан ажиллана. Утас-89740110.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх газар хөдлөх, зуд болох, тахал болон байгалийн бусад хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт импортын хориг ажил хаялт үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 7.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээт хугацаан дээрх нөхцөл байдал арилгах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачилгаар цуцална.
- 7.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Найм. Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах

- 8.1. Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.

- 8.2. Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцон хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй.
- 8.3. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил гүйцэтгээгүй хугацаа хожимдуулсан, цаашид уг ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд түрээслэгчийн санаачилгаар гэрээг цуцална.

Ес. Бусад зүйл

- 9.1. Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, талууд тус тусын үүргээ биелүүлж гэрээг дүгнэснээр дуусгавар болно.
- 9.2. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж Захиалагч 3 хувийг Гүйцэтгэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4. Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.
- 9.6. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

БАТЛАВ

ТҮРЭЭСЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

A handwritten signature in black ink, likely belonging to E. Mönkhjargal.

Э.МӨНХЖАРГАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

A handwritten signature in blue ink, likely belonging to O. Udval.

Ө.УДВАЛ

БАТЛАВ

ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ИРГЭН

A handwritten signature in black ink, likely belonging to A. Batbold.


А.БАТБОЛД

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Г.БАТТУЛГА

АХММХМ ИНЖЕНЕР



Н.САЙНБИЛЭГ

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН



Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН



Ш.ГАНТУЛГА

*Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646*

*Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг 19-р хороо цайзын
17-195 тоот
Утас: 89740110
РД: рэ-78022571.*